

## ТАТВАРЫН ӨР БАРАГДУУЛАЛТ, ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ



### Хушааны Энхбаатар

ШШГЕГ-ын ШГГ-ын дэд дарга бөгөөд мэргэжлийн  
удирдлагын хэлтсийн дарга, хурандаа

Татвар төлөх нь хүн бүрийн угаас заяасан үндсэн үүрэг байхаар Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулан тунхагласан билээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь иргэний, захиргааны болон эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үүрэг бүхий төрийн байгууллага бөгөөд иргэний, захиргааны хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх Шийдвэр гүйцэтгэх газар, эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх Тогтоол гүйцэтгэх газар гэсэн бүтэцтэй үйл ажиллагаа явуулж байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн хөндөгдсөн эрхийг шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн сэргээх, учирсан хохирлыг арилгах, нөгөө талаас төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагааг хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд албадан гүйцэтгэх ажиллагааг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэдэг онцлогтой бөгөөд үүнтэй холбоотой талуудын гаргасан өргөдөл, гомдол, маргааныг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэхэд цаг хугацаа, чирэгдэл багагүй гарч, улмаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад бусдын хууль ёсны эрх, ашиг сонирхолыг хамгаалах, шуурхай, энэрэнгүй байх зарчим цөөнгүй тохиолдолд алдагдаж байгааг үгүйсгэх аргагүй юм.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь нутаг, дэвсгэрийн онцлог нөхцөл байдлаас шалтгаалан тойргын журмаар шүүхийн шийдвэрийг гүйцэтгэдэг бөгөөд улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар нийт 189 тойрогт шийдвэр гүйцэтгэгч ажиллаж байгаагаас нийслэлд 68 шийдвэр гүйцэтгэгч ажиллаж дундажаар орон нутагт нэг шийдвэр гүйцэтгэгчид 118, нийслэлд нэг шийдвэр гүйцэтгэгчид 127 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байна.


Төсвийн орлогыг бүрдүүлэх, татварын өр барагдуулах ажиллагаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага багагүй анхаарал хандуулж, энэ төрлийн шүүхийн шийдвэрийг зохих үр дүнд хүргэх чиглэлээр сүүлийн жилүүдэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Татварын ерөнхий газрын даргын хамтарсан тушаалаар “Ажлын хэсэг” байгуулан,




тусгай төлөвлөгөө гарган хамтран ажилласнаар зохих үр дүнгээ өгч байгаа юм.

Улсын хэмжээнд нийт 12410 гүйцэтгэх баримт бичгийн 157.2 тэрбум төгрөгийн төлбөр, тэтгэлэг барагдуулахаас төрийн байгууллагын нэхэмжлэлтэй 69.3 тэрбум төгрөгийн 1965 гүйцэтгэх баримт бичиг шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаагийн 35.2 тэрбум төгрөгийн 161 гүйцэтгэх баримт бичиг нь татварын байгууллагын нэхэмжлэлтэй байна.

Нийт гүйцэтгэх баримт бичгийн 2.0 хувь, мөнгөн дүнгийн 17.0 хувийг татварын байгууллагын нэхэмжлэлтэй гүйцэтгэх баримт бичиг эзэлж байна.



Татварын байгууллагын нэхэмжлэлтэй нийт өрийн 94.0 хувийг өндөр үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичиг эзлэж байна. Тухайлбал: “Эм Жи Эйч” ХХК 11.0 тэрбум төгрөг, “Жамп” ХХК 6.7 тэрбум төгрөг, “Монгол газар” ХХК 4.8 тэрбум төгрөг, “Алтандорнод Монгол” ХХК 9.6 тэрбум төгрөг, “Жэй ба Э” ХХК 615.7 сая төгрөг, “Ханын материал” ХХК 207.2 сая төгрөгийн татварын өртэй гэх мэт.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу төлбөр гаргуулах чиглэлээр дараахь ажиллагааг явуулж байна. Үүнд:

- төлбөр төлөгчид эд хөрөнгө байгаа эсэх талаар хуульд заасан журмаар мэдээлэл олж авах, төлбөр төлөгчийн мөнгөн хадгаламж болон харилцах данснаас хасалт хийх, эд хөрөнгө болон биед үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, албадан барьцаалах хураах, худалдан борлуулах;



- төлбөр төлөгчөөс эд хөрөнгийн тухай мэдүүлэг авах, өртэй этгээдийн бүртгэлд бүртгэх;
- төлбөр төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос суутгал хийлгүүлэх;
- төлбөр төлөгчийн бусдад байгаа өмч хөрөнгөөс хуульд заасан журмын дагуу төлбөр гаргуулах;
- шийдвэрт нэр заасан тодорхой эд хөрөнгийг төлбөр төлөгчөөс гаргуулж төлбөр авагчид шилжүүлэх, эсхүл тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх;
- хуульд заасан бусад үйл ажиллагаа.

Гэвч төлбөр төлөгч хуулийн этгээд нь он удаан жил үйл ажиллагаа явуулаагүй, төлбөрт гаргуулах эд хөрөнгөгүй, төлбөрийн чадваргүй, төлбөр төлөхөөс санаатайгаар зайлсхийх, эд хөрөнгөө бусдад барьцаалах, шилжүүлэх, битүүмжилсэн эд хөрөнгийг үрэгдүүлэх, төлбөр төлөгч-хуулийн этгээдийн харилцах дансны талаарх мэдээллийг арилжааны банк ирүүлэхгүй байх, татвар төлөгч хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэлгүй, үүсгэн байгуулагч /захирал/ нар гэрийн хаягаар хуулийн этгээд үүсгэсэн, оршин суух тодорхой хаяггүй зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан Шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хуульд заасан албадлагын арга хэмжээ зохих үр дүнд хүрэхгүй байна.

Хуульд заасан үндэслэл, журмын дагуу төлбөр барагдуулах ажиллагааг тухай жилд гүйцэтгэвэл зохих төлбөрийн хэмжээгээр тооцон хэсэгчлэн төлөх төлбөрийн хэмжээг тогтоодог боловч төлбөр төлөгчөөс тогтоосон графикийг зөрчсөнөөс өр төлбөр ихээр хуримтлагдаж, он дамжин үргэлжилж, удаашрах нэг нөхцөл болж байна. Тухайлбал:

- Төлбөр төлөгч “Жамп” ХХК нь 6.7 тэрбум төгрөгийн татварын өрийн үлдэгдэлтэй бөгөөд тус компаний өмчлөлд байсан ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын 24 ширхэг тусгай зөвшөөрлийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн боловч төлбөр төлөгч “Жамп” ХХК-ний захирал Л.Цэрэндаваа нь ашиглалтын 3 тусгай зөвшөөрлийн эрхийг 2011 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр өөрийн охин компани болох “Жамп алт” ХХК-ний эзэмшилд хууль бусаар тусгай зөвшөөрлийн эрхийг шилжүүлсэн байна.

Төлбөр төлөгчийн шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн дээрх санаатай үйлдлийг Цагдаагийн байгууллагад шилжүүлж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 258 дугаар зүйлээр эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулсан боловч Чингэлтэй дүүргийн прокуророос эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзан шийдвэрлэсэн тул дээд шатны прокурорт гомдол гаргаж улмаар холбогдох эрүүгийн хэргийг сэргээлгэн, мөрдөн байцаалтанд буцаалгаад байна.

- Төлбөр төлөгч “Алтандорнод Монгол” ХХК нь 9.7 тэрбум төгрөгийн татварын өрөөс гадна шүүхийн шийдвэрээр иргэд, байгууллагад их хэмжээний өр төлбөртэй тул шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар төлбөрт орж ирсэн мөнгө нийт төлбөр авагч нарт



хувь тэнцэгдэн олгогдож, улмаар дийлэнх эд хөрөнгө нь арилжааны банкинд үүргийн гүйцэтгэлд барьцаалагдсан байдгаас төлбөр гаргуулахад хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэж байгаа юм.

- Сүхбаатар дүүргийн шүүхийн 2011 оны шийдвэртэй төлбөр төлөгч “КПЖВ” ХХК нь 20.1 сая төгрөгийн татварын өртэй боловч бусдад шүүхийн шийдвэрээр 114.4 сая төгрөгийн өртэй, “Монгол нэхмэл” ХХК-ний байранд түрээсээр байрладаг, үйлдвэрийн тоног төхөөрөмж Голомт банкны зээлийн барьцаанд байдаг байна.

- “Эм Жи Эйч” ХХК, “Олон овоот” ХХК-ууд нь татварын өрийг хэсэгчлэн барагдуулах хүсэлт гаргаж байгаа боловч компаний удирдлага тогтвортой бус төлбөрийн мөнгийг тогтоосон хугацаанд барагдуулахгүйгээс өндөр үнийн дүнтэй татварын өр, төлбөр төлөгдөхгүй байна.

- Хан-Уул дүүргийн шүүхийн 2010 оны 845 дугаар шийдвэр мөн шүүхийн 2011 оны 507 дугаар шийдвэрээр “Бөхөг” ХХК-иас 177.4 сая төгрөгийн төлбөрийг татварын байгууллагад олгохоор шийдвэрлэжээ. Гэтэл “Бөхөг” ХХК-ний өмчлөлийн 16 ширхэг шувууны аж ахуйн байр нь Хаан банкинд үүргийн гүйцэтгэлд барьцаалагдсан, өмчлөлд өөр эд хөрөнгө тогтоогдоогүй, уг үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулахаар үнэлгээ тогтоолгосон боловч төлбөр авагчаас шинжээчийн үнэлгээний хөлсийг төлөөгүйгээс шалтгаалан үнэлгээний тайланг гардан аваагүй тул албадан дуудлага худалдаа зохион байгуулах боломжгүй болжээ.

- Баянзүрх дүүргийн шүүхийн 2010 оны 542/А дугаар шийдвэртэй “Жэй ба Э” ХХК нь 615.7 сая төгрөгийн татварын өртэй бөгөөд гүйцэтгэх хуудас 2003 онд захирлаар ажиллаж байсан гэх Эрдэнэчимэгийн хаягаар бичигдэж тус байгууллагад иржээ. Уг хаягт компани үйл ажиллагаа явуулдаггүй, захирлаар ажиллаж байсан гэх Эрдэнэчимэг нь 2006 онд компаниас гарсан, 100 хувийн хөрөнгө оруулагчаар бүртгэгдсэн Zhou Qing 2011 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр БНХАУ-ын Да Лиан хотын эмнэлэгт зүрхний өвчний улмаас нас барсан гэсэн баримт авагдсан байх жишээтэй.

Түүнчлэн төлбөрөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр цагдаа, прокурор, шүүхийн байгууллагад холбогдох материалыг шилжүүлдэг боловч хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалздаг, төлбөр төлөгч-хуулийн этгээдээс цаг хугацаа хожих, өөрт ашигтай нөхцөл байдлыг бий болгох зорилгоор удаа дараа нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөн шүүхэд нэхэмжлэл гаргаж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлдэг.

Жишээ нь: төлбөр төлөгч “Монфорте” ХХК-ний өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийг албадан дуудлага худалдаанд борлуулах явцад эд хөрөнгийн үнэлгээтэй холбогдуулан удаа дараа гомдол гаргаж холбогдох шүүхээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааг 4 удаа түдгэлзүүлжээ.



Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн эзэмшилд байгаа тусгай зөвшөөрлийн захиран зарцуулах эрхийн шилжилт хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон ч ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмших эрхийн хугацаа дууссанаар холбогдох байгууллагаас олгогдсон тусгай зөвшөөрлийг хүчингүйд тооцож, цуцлагдаж байна.

Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч-хуулийн этгээдийн эзэмшлийн тусгай зөвшөөрлийн эрхийг худалдан борлуулах зорилгоор хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар үнэлгээ тогтоолгоход хүндрэлтэй, шинжээчийн үнэлгээний хөлс, зардлыг талууд шийдвэрлэдэггүй, худалдан борлогдоогүй тохиолдолд төлбөр авагч байгууллага төлбөрт тооцон авахаас татгалздаг зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан албадан дуудлага худалдаагаар тусгай зөвшөөрлийн эрхийг борлуулах боломжгүй нөхцөл байдал өнөөдөр бидэнд тулгараад байгаа юм.

Цаашид шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгар буй дээрх хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд:

- Хууль тогтоомж, эрхийн актыг боловсронгуй болгох/шүүхийн шатанд хариуцагчийн эд хөрөнгийг заавал битүүмжилдэг болгох, эрүүгийн хэрэг үүсгэсэн нөхцөлд тухайн сэжигтний эд хөрөнгийг заавал хамгаалдаг байх/

- Хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлж, хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх,

- Хуулийн болон татварын байгууллагуудын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж, хамтран ажиллах,

- Боловсон хүчний мэдлэг, чадвар, мэргэшлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр давтан сургалтанд байнга хамруулах,

- Төрийн байгууллагуудыг нэгдсэн мэдээлэл хангалтгүй байгаа тул нэгдсэн мэдээллийн сүлжээнд холбох,

- Эрсдлийг урьдчилан тооцож, урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажлыг зохион байгуулах

- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг талуудад ил тод нээлттэй болгох,

Энэхүү зөвлөгөөнөөс татвар төлөгч нарт чиглэсэн тодорхой зөвлөмж, хуулийн байгууллагуудын хамтын ажиллагааны чиглэлээр үнэтэй санал, санаачлага гарч байна. Үүнд ажил хэрэгчээр хандаж, хэрэгжүүлэн ажиллахыг хүсэж, энэ ажилд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага бүхий талаар дэмжиж, хамтран ажиллах болно.